



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН ИХ СУРГУУЛИЙН
2017 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН
ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТ

Аудитын код: САГ-2018/286/СТА-ТӨҮГ

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

2018 он

**МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН ИХ СУРГУУЛИЙН
2017 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН
ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Аудитын код: САГ-2018/286/СТА-ТӨҮГ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер С.Оюунгэрэл
Утас: 261885 Цахим хаяг: oyungerels@audit.gov.mn

Ахлах аудитор Д.Цэрэндорж
Утас: 261740 Цахим хаяг: tserendorjd@audit.gov.mn

Гэрээгээр гүйцэтгэсэн:
"Нийслэл аудит" ХХК
Утас: 70110095 Цахим хаяг: info@niislelaudit.mn

2018 оны 3 дугаар сар

Улаанбаатар хот

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	0
2	Аудитын тайлан.....	1
2.1	Оршил.....	1
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	1
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	2
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	2
2.5	Дотоод хяналт.....	3
2.6	Орлого зарлагын гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	3
2.7	Шилэн дансны мэдээлэл.....	3
2.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар.....	3
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл.....	3
2.9.1	Суралцагчдаас авах авлагын талаар.....	3
2.9.2	Үндсэн хөрөнгийн бүртгэлийн талаар.....	4
2.9.3	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар.....	4
2.9.4	Дотооддоо шилжүүлсэн үндсэн хөрөнгө бараа материалын бүртгэлийн талаар.....	5
2.9.5	Тус сургуулийн дэд захиралын унаанд зарцуулсан шатахууны талаар.....	5
2.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	6
2.11	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд.....	6
2.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл.....	6
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	6
2.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:.....	6
2.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	6
3	Менежментийн захидал.....	7
3.1	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар.....	8
3.2	Тус сургуулийн дэд захиралын унаанд зарцуулсан шатахууны талаар.....	9
4	Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	10-11
4.2	Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	12-14
4.3	Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	15
4.4	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	16-18
4.5	Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	19-20
5	Байгууллагын удирдлагын хариу.....	21-23



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН
ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ Д.МАНДАХ
ТАНАА

2018.03.14 № 06/668
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монгол Улсын Боловсролын Их сургуулийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Монгол Улсын Боловсролын Их сургуулийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Монгол Улсын Боловсролын Их сургуулийн 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

\\10.10.10.20\Bichig_KhereglYawsan_Bichig\2018\0315SAG97.Docx

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ


071333

Үүрэг, хариуцлага

Байгууллагын удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН
ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ
Д.МАНДАХ ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монгол Улсын Боловсролын Их сургуулийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Монгол Улсын Боловсролын Их сургуулийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Монгол Улсын Боловсролын Их сургуулийн 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Байгууллагын удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт

01

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Монгол Улсын Боловсролын Их сургуулийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Монгол Улсын Боловсролын Их сургуулийн захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Мандах танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулагдсан материаллаг алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр хассан авлагыг залруулан бүртгэх, бүрэлдэхүүн сургууль хооронд хийгдсэн ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэлийн дансны бичилтээр цэвэрлэж санхүүгийн тайланд тайлагнах, бүртгэлд тусгаагүй үндсэн хөрөнгийг бүртгэх, өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигийг боловсруулж мөрдөж ажиллах, санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэх зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монгол Улсын Боловсролын Их сургуулийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитыг Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Монгол Улсын Боловсролын Их сургуулийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Монгол Улсын Боловсролын Их сургуулийн удирдлага санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 2 дугаар сарын 22-ноос 2018 оны 3 дугаар сарын 13-ны хооронд хийж, аудитын тайланг 2018 оны 3 дугаар сарын 20-нд эцэслэн баталгаажуулж, Монгол Улсын Боловсролын Их сургуулийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, “Нийслэл Аудит” ХХК-ийн аудитор Б.Өлзийзаяа, ахлах шинжээч Д.Чулуунбаатар нар хариуцаж хэрэгжүүлэв.

Монгол Улсын Боловсролын Их сургуулийн удирдлага нь 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг 2018 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн 3/420 тоот албан бичгээр “Нийслэл Аудит” ХХК-д ирүүлсэн байна.

2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Монгол Улсын Боловсролын Их сургууль санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай болон бусад холбогдох хуулиуд, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан, тодруулгын маягт, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал” зэрэг эрх зүйн актуудыг мөрдөж байна.

Монгол Улсын Боловсролын Их сургууль нь “Хүүхэд бүрийг хөгжүүлэх чадамжтай багш, боловсролын салбарын мэргэжилтэн бэлтгэн гаргах” гэсэн эрхэм зорилгын хүрээнд бүрэлдэхүүний найм, салбар нэг, Захиргаа аж ахуй, Иновацийн төв, Оюутанд үйлчлэх төв зэрэг 10 дотоод албатай үйл ажиллагаагаа явуулж байна. 2017 онд тус сургуулийн бүтэц бүрэлдэхүүн болон удирдлагад өөрчлөлт орсон байна.

Монгол Улсын Боловсролын Их сургуулийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд төлөвлөсөн хэмжээнд судалж, баримтжуулсан.

2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Монгол Улсын Боловсролын Их сургуулийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлж баримтжууллаа.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 15 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 45 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 2.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

Монгол Улсын Боловсролын Их сургуулийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтний оролцоо шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ.

Монгол Улсын Боловсролын Их сургууль нь санхүүгийн тайлангаа нягтлан бодох бүртгэлийн "Acolums", "Payroll" програм хангамжаар бэлтгэсэн байна.

2.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Монгол Улсын Боловсролын Их сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

2.6 Орлого зардлын гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Монгол Улсын Боловсролын Их сургуулийн удирдлага нь 2017 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу арилжааны банкууд дах харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Тус сургуулийн удирдлага нь 2017 онд өөрийн үйл ажиллагаанаас 27,810.1 сая төгрөг, улсын төсөв болон хөрөнгө оруулалтаас 8,527.5 сая төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөж, тайлант жилд өөрийн үйл ажиллагаанаас 29,586.4 сая төгрөгийн орлого олж, 3,052.6 сая төгрөгийн санхүүжилт авч, гүйцэтгэлээр 26,468.3 сая төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулжээ.

2.7 Шилэн дансны мэдээлэл

Монгол Улсын Боловсролын Их сургууль нь Шилэн дансны тухай хуульд заасны дагуу хуульд заасан хугацаанд жил, улирал, сар, тухай бүр оруулах мэдээллийг оруулсан байна. Байгууллагын цахим хуудас <http://www.mnue.mn/> сайтад шилэн дансны цэсийг холбосон. Шилэн дансны сайтад байгууллагын тухайн жилийн төсөв, гүйцэтгэл, цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, санхүүжилт, бараа, ажил үйлчилгээ худалдан авсан нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаяг мэдээллийг оруулсан. Мөн бүрэлдэхүүн сургууль бүрээр болон нэгтгэсэн жилийн эцсийн санхүүгийн тайланг оруулсан байна. Тайлант онд Нийцлийн аудитын газраас шилэн дансны шалгалт орж, ямар нэгэн алдаа зөрчлийн зөвлөмж өгөгдөөгүй байна.

2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 15 чиглэлээр эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 45 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны "Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах" гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 2.9-д хураангуйлан тэмдэглэв.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

2.9.1 Суралцагчдаас авах авлагыг данснаас хассан талаар

Монгол Улсын Боловсролын Их сургуулийн захирлын 2017 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн А/173, мөн сургуулийн захирлын үүрэг гүйцэтгэгчийн 2017 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/340 болон А/341 тоот тушаалууд гарч оюутан, магистрантур, докторантурт суралцагчдаас авах нийт 1,152.2 сая төгрөгийн авлагыг залруулах тухай тушаал гаргаж данснаас хассан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т заасан “Нягтлан бодох бүртгэл нь үнэн зөв байх” гэсэн зарчим, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны зааврын 3.12-т “Найдваргүй авлагыг бүртгэхдээ авлагыг хорогдуулах хэмжээ, баримтлах зарчим, нөхцөлийг заасан эрх бүхий байгууллагын найдваргүй болсон авлагыг данснаас хасах тухай шийдвэрийг үндэслэнэ. Шийдвэр гартал уг найдваргүй болсон авлагыг санхүүгийн тайланд авлагаар тусгана”, БСШУС-ын сайдын 2017 оны А/40 тоот тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн 3 дугаар бүлгийн 3.1.3-т заасан авлагын бүртгэлд “Шүүхийн шийдвэр болон хуулийн байгууллагын баримтаар төлөгдөх найдваргүй болох нь тогтоогдсон авлагыг жил бүрийн эцэст байгууллагын удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлж данснаас хасна” гэж заасныг тус тус зөрчжээ.

Шийдвэрлэсэн нь: Орлого, авлагыг бууруулсан 1,152.2 сая төгрөгийн хэмжээгээр дансны бичилт хийж 2017-12-31-нээрх санхүүгийн тайлангаа залруулах, цаашид авлагыг данснаас хасахдаа Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны зааврын 3.12-т заасны дагуу шүүх, хуулийн байгууллагад хандан шийдвэрлэж байх талаар зөвлөмж хүргүүлэх.

2.9.2 Үндсэн хөрөнгийн бүртгэлийн талаар

Архангай аймаг дахь салбар сургуулийн 2,101.6 сая төгрөгийн өртөг бүхий оюутны дотуур байрны барилга, хэвлэх цехэд худалдан авсан 99.8 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг үндсэн хөрөнгөд бүртгээгүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.1-д аж ахуйн бүх ажил, гүйлгээ” мөн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “Нягтлан бодох бүртгэл нь үнэн зөв байх” гэж заасныг зөрчиж, аудитын “Бодитоор оршин байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлж үндсэн хөрөнгүүдийг нягтлан бодох бүртгэлд тусгаж цаашид анхаарч ажиллах талаар зөвлөмж хүргүүлэх.

2.9.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Тус сургууль нь Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын сайдын 2017-02-07-ны өдрийн А/40 тоот тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөж ажиллаж байна. Энэ бодлогын баримт бичигт бакалавр, магистрын боловсрол эзэмшихээр суралцагчдын сонгон суралцсан кредит цаг болон сургалтын албаны мэдээлэлтэй хэрхэн уялдуулж сургалтын орлогыг хүлээн зөвшөөрөх, урьдчилж орсон орлого, авлагыг хэрхэн

бүртгэх, бүрэлдэхүүний болон салбар сургуулиуд нэгдэх, салах, дотооддоо санхүүжилт олгох, жилийн эцэст зарцуулагдаагүй санхүүжилтийн үлдэгдлийг төвлөрүүлэх, үндсэн болон эргэлтийн хөрөнгө шилжүүлэх, хүлээн авах болон нэгдсэн санхүүгийн тайлан гаргахад ямар ажил гүйлгээг цэвэрлэж /устгаж/ гаргах гэх мэт боловсролын байгууллагын онцлогтой холбоотой чухал асуудлыг данс бүртгэл, санхүүгийн тайланд тусгах талаар тодорхой дурдаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлж сургуулийнхаа үйл ажиллагааны онцлогийг тусгасан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан мөрдөж ажиллах зөвлөмж хүргүүлэх.

2.9.4 Дотооддоо шилжүүлсэн үндсэн хөрөнгө, бараа материалын бүртгэлийн талаар

Монгол Улсын Боловсролын Их сургууль болон түүний салбар, бүрэлдэхүүн сургуулиуд өөр хоорондоо 975.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, бараа материалыг үнэ төлбөргүй шилжүүлж нягтлан бодох бүртгэлд орлого болон зардлаар тусгажээ.

Энэ нь Сангийн сайдын 2015 оны 341 тоот тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан "Санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.2-т "Давхардсан ажил, гүйлгээг устгах бичилтийг бүрэн хийнэ. Үүнд нэгтгэлд хамрагдсан байгууллага хоорондын авлага, өглөгийн дансны үлдэгдэл, орлого болон зардлын ажил гүйлгээ гэх мэт давхардсан гүйлгээг устгана" гэж заасныг зөрчжээ.

Шийдвэрлэсэн нь: Сангийн сайдын 2015 оны 341 тоот тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан "Санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам"-ын дагуу Монгол Улсын Боловсролын Их сургуулийн нэгдсэн санхүүгийн тайлангийн Санхүүгийн үр дүнгийн тайланд тусгасан 975.1 сая төгрөгийн орлого, зарлагыг цэвэрлэж, санхүүгийн тайланд тусгах зөвлөмж хүргүүлэх.

2.9.5 Тус сургуулийн дэд захирлуудын унаанд зарцуулсан шатахууны талаар

Монгол Улсын Боловсролын Их сургуулийн захирлын үүрэг гүйцэтгэгчийн 2017 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн А/316 тоот тушаалаар сургуулийн дэд захирлуудад сар бүр албан хэрэгцээний зориулалтаар 0,2 сая төгрөгийн шатахууныг олгохоор зөвшөөрч нийт 0.3 сая төгрөгийг олгосон байна.

Энэ нь Засгийн газрын 2015 оны 184 дүгээр тогтоолоор "Албан тушаалын болон албан ажлын суудлын автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтны жагсаалт"-ыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Сургуулийн удирдлагад гаргасан шийдвэрээ залруулж, үргүй зарцуулсан хөрөнгийг барагдуулж, байгууллагыг хохиролгүй болгох зөвлөмж хүргүүлэх.

2.10 Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Цаашид Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан Сангийн сайдын баталсан журам зааварт нийцсэн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан ажиллах.

2.11 Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

2017 оны аудитаар илэрсэн зөрчлүүдийн залруулгыг шалгаж, үйл ажиллагааны орлого, зарлага, шатахууны зардал, дотоод томилолтын зардал, үндсэн хөрөнгө орлого зарлагын дансдын ажил гүйлгээг 2018 оны завсрын аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

2.12 Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Монгол Улсын Боловсролын Их сургуулийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 4,328.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба 4,328.9 сая төгрөгийн зөрчилд 5 зөвлөмж өгсөн.

2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Монгол Улсын Боловсролын Их сургуулийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар 4 зөвлөмж өгөгдсөн байна. Өгөгдсөн 3 зөвлөмжийг бүрэн биелүүлж, 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

2.14 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгов.

Монгол Улсын Боловсролын Их сургуулийн 2017 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого нь 32,638.9 сая төгрөг бөгөөд 1 хувиар буюу 326.4 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

2.15 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Монгол Улсын Боловсролын Их сургуулийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

3 Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Монгол Улсын Боловсролын Их сургуулийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан зөвлөмжүүд цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.

3.1 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар**Тэргүүлэх ач холбогдол №1****ҮАГ-ын ажиглалт**

Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын сайдын 2017-02-07-ны өдрийн А/40 тоот тушаалаар сургуулийн санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталжээ. Энэ тушаалд Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагад НБББББ-ийг 2017 оны 1 дүгээр сарын 1-нээс мөрдөхөөр заажээ.

Энэ бодлогын баримт бичигт бакалаврын, магистрантурын боловсрол эзэмшихээр суралцагчдын сонгон суралцсан кредит цагтай болон сургалтын албаны мэдээлэлтэй хэрхэн уялдуулж сургалтын орлогыг хүлээн зөвшөөрөх, урьдчилж орсон орлого, авлагыг хэрхэн бүртгэх, бүрэлдэхүүний болон салбар сургуулиуд нэгдэх, салах, дотооддоо санхүүжилт олгох, жилийн эцэст зарцуулагдаагүй санхүүжилтийн үлдэгдлийг төвлөрүүлэх, үндсэн болон эргэлтийн хөрөнгө шилжүүлэх, хүлээн авах болон нэгдсэн санхүүгийн тайлан гаргахад ямар ажил гүйлгээг цэвэрлэж /устгаж/ гаргах гэх мэт боловсролын байгууллагын онцлогтой холбоотой чухал асуудлыг данс бүртгэл, санхүүгийн тайланд тусгах талаар тодорхой дурдаагүй байна.

Эрсдэлүүд

Бүртгэлийн нэгдсэн бодлого дутмагаас хөрөнгө, өр төлбөр, эздийн өмчийн үнэлгээ, хуваарилалт, хөдөлгөөнийг буруу тайлагнаснаас салбар, системийн тайлан ташаа гарч санхүүгийн тайланг хэрэглэгчид болон удирдлагад буруу мэдээлэл өгч тэдний шийдвэрт нөлөөлөх эрсдэлтэй.

ҮАГ-ын зөвлөмж

Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэж заасныг хэрэгжүүлэх үүднээс сургуулийнхаа үйл ажиллагааныхаа онцлогийг тусгасан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2018 оны эхний хагас жилд боловсруулан үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг зөвлөж байна.

Сургуулийн удирдлагын хариу

Монгол Улсын Боловсролын Их сургуулийн удирдлагын зүгээс аудитаар илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч, цаашид анхаарч ажиллах талаар хариу ирүүлсэн.

3.2 Тус сургуулийн дэд захирлын унаанд зарцуулсан шатахууны талаар

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Монгол Улсын Боловсролын Их сургуулийн захирлын үүрэг гүйцэтгэгч Монгол Улсын Засгийн газрын 2002 оны 120 тоот тогтоолыг үндэслэн (ЗГ-ын 120 тоот тогтоол нь 2007 оны 349 тоот тогтоолоор, 349 тоот тогтоол нь 2015 оны 184 тоот тогтоолоор тус тус хүчингүй болжээ) 2017-12-08-ны өдрийн А/316 тоот тушаалаар Монгол Улсын Боловсролын Их сургуулийн дэд захирал нарт сар бүр албан хэрэгцээний зориулалтаар 240.0 мянган төгрөгийг шатахууны зардалд олгохоор шийдвэрлэж, 2017-12-31-ний байдлаар 317.97 мянган төгрөгийг олгожээ.

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 184 тоот тогтоолоор Төрийн байгууллагуудын суудлын автомашиныг зориулалтаар нь “албан тушаалын, албан ажлын, дуудлагын, хөдөө ажлын” гэж ангилан тогтоож, “Албан тушаалын болон албан ажлын суудлын автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтны жагсаалт”-ыг баталжээ. Энэхүү баталсан “Албан тушаалын болон албан ажлын суудлын автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтны жагсаалт”-д их, дээд сургуулийн дэд захирал түүнтэй адилтгах албан тушаалтан байхгүй байна.

Эрсдэлүүд

Сургуулийн удирдлагын эрсдэлтэй шийдвэрээс үүдэн улсын хөрөнгийг үр ашиггүй зүйлд зарцуулж тайлагнасан нь буруу жишиг тогтож, хэрэглэгчид болон удирдлагын шийдвэрт нөлөөлөх эрсдэлтэй.

ҮАГ-ын зөвлөмж

Сургуулийн удирдлага гаргасан шийдвэрээ залруулж, үргүй зарцуулсан хөрөнгийг барагдуулж 2018 оны 1 дүгээр улиралд багтаан байгууллагыг хохиролгүй болгох.

Сургуулийн удирдлагын хариу

Монгол Улсын Боловсролын Их сургуулийн удирдлагын зүгээс аудитаар илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч, цаашид анхаарч ажиллах талаар хариу ирүүлсэн.

4. Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	29,684,892,391.53	37,052,182,219.56
МӨНГӨН ХӨРӨНГӨ	15,916,850,257.01	26,183,722,480.07
Кассанд байгаа бэлэн мөнгө		
Төгрөг		
Банкинд байгаа бэлэн мөнгө	11,999,531,713.49	26,183,722,480.07
